

СУРГУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА



Мандал сургууль нь анх 2014 оны 12 сард ашиглалтанд орж үйл ажиллагаагаа эхлүүлээд Ерөнхий боловсролын “Мандал” сургууль нь Дундговь аймгийн засаг даргын 2015 оны 01 сарын 20-ны өдрийн А/17 тоот захирамжаар ерөнхий боловсролын сургууль болж сургалтын үйл ажиллагааг явуулж эхэлсэн. Тус сургууль нь 2023-2024 оны хичээлийн жилд 49 багш , 30 ажилчидтай, 1-12-р ангийн 32 бүлэгт 1078 сурагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Зөвлөх багш 3, Тэргүүлэх 10, заах аргач 20, ахлах 2, мэргэжлийн зэрэгтэй, мэргэжилтэй боловсон хүчнээр 100% хангагдсан. Ахлах , дунд , бага , захиргаа аж ахуй гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй.

* Зориулалтын стандартад нийцсэн сурагчдын эрүүл таатай сурч хөгжих нөхцөлөөр хангагдсан шинэ сургуулийн байртай.

Спорт заалтай, урлаг заалтай, дотуур байртай.

* Аймаг, бүс, улсын олимпиад, уралдаан тэмцээнүүдийн аварга, шилдэг, чадварлаг багш нартай.

* “Эцэг эхийн өдөрлөг” жилд 1-2 удаа тогтмол зохион байгуулагддаг.

* 8 төрлийн сонгон, 27 төрлийн дугуйлан, 5 төрлийн секцээс дуртайгаа сонгон суралцаж хөгжих боломтой.

* 2 ээлжээр хичээллэдэг

Амжилт

2015 онд аймгийн Шилдэг бүтээн байгуулалттай байгууллага

2016-2017 аймгийн БСУГ-ын “Зорилтын хэрэгжилтээр ТЭРГҮҮЛЭГЧ сургууль”

2017 онд Сайнцагаан сумын Шилдэг Эко сургууль

2018 онд Аймгийн Шилдэг Эко сургууль, Сайнцагаан сумын Төсвийн шилдэг байгууллага

2018-2019 оны хичээлийн жилийн Бага боловсролын чанарын үнэлгээгээр Тэргүүлэгч сургууль

2019 онд Сайнцагаан сумын Тэргүүний хамт олон

2020 Олон Улсын Эко сургууль хөтөлбөрийн Хүрэл Гэрэгэ өргөмжөл

Санаачлан зохион байгуулсан ажлууд:

-Аймгийн “Байгаль орчны газар”-тай хамтран сургуулийн гадна орчинд 9 сая төгрөгийн хөрөнгөөр “Жишиг ногоон төгөл”-ийг багш, сурагчид, эцэг эхчүүдийн хамтын хөдөлмөрөөр байгууллаа.

-БСШУСЯ-ын захиалгаар гүйцэтгэгдсэн 940 сая төгрөгийн өртөг бүхий “Спорт зал”-ыг хүлээн авч тохижуулан, сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

-Ургацын баяр /өөрсдийн нөөц бололцоог ашиглан хүнсний ногоо тариалан, ургацаа хураав

-Дотуур байр тохижуулан ашиглалтанд оруулав.

-Сургуулийн гадна талбайд 20-25 машины унадаг дугуй зогсоолыг багш, ажилчидын санаачилгаар хийж гүйцэтгэлээ.

- Pearson English Олон улсын англи хэлний хөтөлбөрийг 5-9-р ангийн хүүхдүүдийн дунд хэрэгжүүлж зохион байгуулсан.